

ДОРНОД АЙМАГ  
БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ  
ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/35

Чойбалсан

Төлбөрийн хэмжээг тогтоох тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 24.4, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 13 дугаар зүйлийн 13.1, 9 дэх заалт, БОЭТөвийн захирлын 2017 оны А/78 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. БОЭТөвд хийгдэж буй өндөр өртөгтэй шинэ технологийн тусламж үйлчилгээнд хамрагдах дурангийн аргаар хийгдэх мэс заслын төлбөрийн хэмжээг 530000 төгрөгөөр тогтоосугай.

2. Эрүүл мэндийн даатгалд даатгуулсан иргэнээс ЭМД-ын сангаас төлөх зардлын зөрүүгээр төлбөрийн хэмжээг тооцон авахыг Эдийн засаг, санхүүгийн албаны дарга С.Ариунтуяа, Мэс засал, гэмтлийн тасгийн эрхлэгч Ф.Болортуяа нарт зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмчилгээ эрхэлсэн дэд захирал Ж.Энхчимэг, Чанарын албаны дарга Д.Ганхүрэл нарт даалгасугай.

